



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэн-Уул сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/70/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай хот
2024 он

Төрийн аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506
Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитор: Г.Баасанжаргал
Утас: 99032514
Цахим хаяг: baasanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.4.1 Мөнгөн хөрөнгө	14
3.5.2 Авлага.....	15
3.5.3 Урьдчилгаа	15
3.5.4 Бараа материал	15
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө	16
3.5.6 Үндсэн хөрөнгө	16
3.5.7 Өр төлбөр	16
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо.....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
4.7.1 Завсрын аудитын талаар	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Төлбөрийн акт	21
5.2 Албан шаардлага.....	21
5.3 Зөвлөмж	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.03.18 № 249

танай _____-ны № _____-т

ЦЭЦЭН-УУЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.ОРГИЛСАЙХАН-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цэцэн-Уул сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэцэн-Уул сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Цэцэн-Уул сумын Засаг даргын 2023 оны санхүүжилтийг өмнөх онтой харьцуулахад 866,491.3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь татвар болон татварын бус орлого 29,297.8 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 124,394.8 мянган төгрөгөөр, тус онд цалин нэмэгдсэнтэй холбогдуулан орон нутгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 202,509.6 мянган төгрөгөөр, татварын орлогын санхүүжилт 462,984.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн болон нэмэлт санхүүжилийн орлого 43,620.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгосон, төвлөрүүлэх шилжүүлэг 3,685.0 мянган төгрөгөөр өссөн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Цэцэн-Уул сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар Төсвийн шууд захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжсан Галуутайн голын гүүрний далан засах ажилд шууд гэрээ байгуулан гэрээлэгчийн хувийн

дансанд 14,000.0 мянган төгрөг шилжүүлсэн ч тухайн ажил тайлант онд огт хийгдээгүй, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас эрх шилжиж ирсэн сумын төвийн гэрэлтүүлгийн ажлын гэрээ хугацаандаа хийгдээгүй, тайлант онд 20,000.0 мянган төгрөгийн ажил хийгдсэн ч үр дүнгүй;

- Засаг даргын нөөц хөрөнгөөс нутгийн зөвлөлийн уулзалт золголтод 5,000.0 мянган төгрөгөөр хүнсний материал худалдан авсан, аймгийн 100 жилийн ойд хандив өгсөн хүмүүст гарын бэлэг, дурсгалын зүйлс 6,899,00 төгрөгөөр худалдан авч зориулалт бус зардал гаргасан;

- Хоршоог хөгжүүлэх сангаас санхүүгийн дэмжлэг авч гэрээт хугацаандаа төлөөгүй иргэдийн материалыг шүүхэд шилжүүлээгүй, шүүхээс гарсан шийдвэрийг хэрэгжүүлээгүй иргэдийн зээлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлэн шийдвэрлүүлээгүй 16 иргэний 31,882.4 төгрөгийн зээлийн үлдэгдэл зэрэгт хяналт тавьж, төсвийг зохистой удирдаагүй зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Цэцэн-Уул сумын Засаг дарга нь 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 61 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн биелэлтийг 91.4 хувьтай хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	377,536,060.24	525,003,189.64
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	113,831,076.99	294,316,389.24
31100	Кассад байгаа бэлэн мөнгө	0.08	0.08
31110	Төгрөг	0.08	0.08
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	113,831,076.91	294,316,389.16
31210	Төгрөг	113,831,076.91	294,316,389.16
31211	Төрийн сангийн харилцах	113,831,076.91	294,316,389.16
33	АВЛАГА	227,355,427.05	193,233,784.20
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0	482,137.20
33500	Бусад авлага	227,355,427.05	192,751,647.00
33510	Байгууллагаас авах авлага	29,560.05	0
33520	Хувь хүмүүсээс авах авлага	227,325,867.00	192,751,647.00
35	БАРАА МАТЕРИАЛ	36,349,556.20	37,453,016.20
35400	Хангамжийн материал	33,149,556.20	34,253,016.20
35410	Бичиг хэргийн материал	2,848,675.00	2,789,975.00
35420	Аж ахуйн материал	25,211,091.20	26,546,591.20
35430	Сэлбэг хэрэгсэл	3,779,450.00	3,779,450.00
35440	Түлш, шатах тослох материал	202,340.00	0
35450	Барилгын засварын материал	598,000.00	627,000.00
35470	Бусад хангамжийн материал	510,000.00	510,000.00
35600	Мал амьтад	3,200,000.00	3,200,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	621,750,355.52	622,717,598.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	621,750,355.52	622,717,598.44
39200	Биет хөрөнгө	619,291,980.52	620,911,723.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	618,123,681.00	618,123,681.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-150,332,106.38	-175,567,880.54
39203	Авто-тээврийн хэрэгсэл	153,384,800.00	156,584,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-112,162,950.70	-121,032,088.53
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	70,954,119.40	122,605,599.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-50,687,124.19	-60,420,957.96
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,569,277.00	32,569,277.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,836,740.52	-29,443,389.98
39214	Бусад үндсэн хөрөнгө	152,541,410.00	156,100,410.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-71,006,435.09	-81,351,776.95
39217	Ном	2,744,050.00	2,744,050.00
39300	Биет бус хөрөнгө	2,458,375.00	1,805,875.00
39301	Программ хангамж	4,002,000.00	4,002,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,837,625.00	-3,490,125.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,294,000.00	1,294,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	999,286,415.76	1,147,720,788.08
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	25,153.82	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	25,153.82	0
41300	Өглөг	25,153.82	0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	25,153.82	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	999,261,261.94	1,147,720,788.08
51	Засгийн газрын хувь оролцоо	999,261,261.94	1,147,720,788.08

51100	Засгийн газрын оруулсан капитал	334,974,312.24	334,974,312.24
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	334,974,312.24	334,974,312.24
51200	Хуримтлагдсан үр дүн	444,354,220.92	592,813,747.06
51210	Өмнөх үеийн үр дүн	3,886,603,846.03	444,354,220.92
51220	Тайлант үеийн үр дүн	3,442,249,625.11	148,459,526.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	219,932,728.78	219,932,728.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	999,286,415.76	1,147,720,788.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	996,673,906.70	1,871,787,189.85
11	ТАТВАРЫН ОРЛОГО	157,162,106.04	212,070,367.95
110	Орлогын албан татвар	135,112,051.38	163,967,002.31
1100	Хувь хүний орлогын албан татвар	157,807,710.54	181,278,056.14
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	102,013,581.95	131,209,260.34
110002	Үйл ажиллагааны орлого	27,719,896.24	22,497,225.14
110003	Хөрөнгийн орлого	22,836,454.71	25,970,624.31
110004	Хөрөнгө борлуулсны орлого	2,340,000.00	600,946.35
110008	Шууд бус орлого	2,897,777.64	1,000,000.00
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-22,695,659.16	-17,311,053.83
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-22,695,659.16	-17,311,053.83
113	Хөрөнгийн албан татвар	21,143,694.66	20,775,727.64
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1,482,994.66	837,327.64
113002	Бууны албан татвар	702,000.00	977,500.00
113004	Малд ногдуулах албан татвар	18,958,700.00	18,960,900.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	906,360.00	27,327,638.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	547,000.00	1,617,951.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	84,500.00	271,357.00
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	227,500.00	1,326,594.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	235,000.00	20,000.00
1181	Газрын төлбөр	314,360.00	203,192.00
118101	Газрын төлбөр	314,360.00	203,192.00
118102	Дуудлага худалдаа	0	0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	45,000.00	25,506,495.00
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	45,000.00	3,371,245.00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0	20,880,000.00
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0	1,255,250.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,654,583.00	62,666,180.94

120	Нийтлэг татварын бус орлого	79,654,583.00	62,666,180.94
120001	Хувьцааны ногдол ашиг	0	0
120002	Хүүгийн орлого	2,423,083.00	1,467,247.97
120003	Торгуулийн орлого	0	1,476,512.97
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,133,000.00	15,903,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,133,000.00	15,903,500.00
120009	Бусад орлого	314,500.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	54,000,000.00	43,042,420.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	5,784,000.00	776,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	759,857,217.66	1,597,050,640.96
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,068,000.00	61,688,051.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,068,000.00	61,688,051.60
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	741,789,217.66	1,535,362,589.36
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	425,411,900.00	888,396,000.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	1,039,665.66	4,724,589.36
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	209,738,600.00	412,248,200.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	105,599,052.00	229,993,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	878,160,272.02	1,563,830,937.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	878,160,272.02	1,563,830,937.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	446,208,204.36	936,528,107.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	256,091,433.14	388,296,672.40
210101	Үндсэн цалин	209,737,873.19	276,378,918.97
210102	Нэмэгдэл	43,882,378.95	110,010,666.11
210104	Урамшуулал	2,471,181.00	1,907,087.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,386,170.81	74,312,356.35
210201	Тэтгэврийн даатгал	24,606,591.52	51,627,980.22
210202	Тэтгэмжийн даатгал	1,952,909.45	5,918,432.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,632,904.43	4,500,945.79
210204	Ажилгүйдлийн даатгал	381,977.70	1,012,121.49
210205	Эрүүл мэндийн даатгал	3,811,787.71	11,252,876.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,734,400.39	27,034,330.92
210301	Гэрэл, цахилгаан	2,263,991.79	2,761,394.92
210302	Түлш, халаалт	26,470,408.60	24,272,936.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,222,310.20	24,483,319.26
210401	Бичиг хэрэг	2,430,760.00	3,572,700.00

210402	Тээвэр, шатахуун	13,468,550.20	18,266,619.26
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,323,000.00	2,644,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,558,500.00	2,947,300.00
210604	Урсгал засвар	1,558,500.00	2,947,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,938,000.00	5,250,000.00
210702	Дотоод албан томилолт	1,938,000.00	5,250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,285,218.00	670,474.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	753,800.00	600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	234,450.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,148.00	48,474.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	0
210807	Газрын төлбөр	23,820.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106,992,171.82	413,533,654.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,941,401.96	355,440,497.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	510,500.00	650,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,540,269.86	57,443,157.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	431,952,067.66	627,302,829.85
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	431,952,067.66	627,302,829.85
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	425,411,900.00	591,337,300.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,039,665.66	15,638,090.25
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,500,502.00	20,327,439.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	118,513,634.68	307,956,252.14
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,560,763,259.79	159,496,726.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	561,249.00	0
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	3,439,639,876.31	159,496,726.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	120,562,134.48	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-3,442,249,625.11	148,459,526.14

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	---

1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	806,292,792.20	828,502,802.20	2,824,963,088.31	4,459,758,682.71
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	471,318,479.96	608,570,073.42	1,061,640,757.72	-18,247,795.66
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	334,974,312.24	219,932,728.78	3,886,603,846.03	4,441,510,887.05
9	Тайлант үеийн үр дүн	0	0	3,442,249,625.11	3,442,249,625.11
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	334,974,312.24	219,932,728.78	444,354,220.92	999,261,261.94
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	334,974,312.24	219,932,728.78	444,354,220.92	999,261,261.94
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	334,974,312.24	219,932,728.78	444,354,220.92	999,261,261.94
19	Тайлант үеийн үр дүн	0	0	148,459,526.14	148,459,526.14
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	334,974,312.24	219,932,728.78	592,813,747.06	1,147,720,788.08

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	996,169,200.95	1,862,660,489.85
11	ТАТВАРЫН ОРЛОГО	157,162,106.04	212,070,367.95
110	Орлогын албан татвар	135,112,051.38	163,967,002.31
1100	Хувь хүний орлогын албан татвар	157,807,710.54	181,278,056.14
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	102,013,581.95	131,209,260.34
110002	Үйл ажиллагааны орлого	27,719,896.24	22,497,225.14
110003	Хөрөнгийн орлого	22,836,454.71	25,970,624.31
110004	Хөрөнгө борлуулсны орлого	2,340,000.00	600,946.35
110008	Шууд бус орлого	2,897,777.64	1,000,000.00
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-22,695,659.16	-17,311,053.83
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-22,695,659.16	-17,311,053.83
113	Хөрөнгийн албан татвар	21,143,694.66	20,775,727.64
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1,482,994.66	837,327.64
113002	Бууны албан татвар	702,000.00	977,500.00
113004	Малд ногдуулах албан татвар	18,958,700.00	18,960,900.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	906,360.00	27,327,638.00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	547,000.00	1,617,951.00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	84,500.00	271,357.00

118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	227,500.00	1,326,594.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	235,000.00	20,000.00
1181	Газрын төлбөр	314,360.00	203,192.00
118101	Газрын төлбөр	314,360.00	203,192.00
118102	Дуудлага худалдаа	0	0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	45,000.00	25,506,495.00
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	45,000.00	3,371,245.00
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0	20,880,000.00
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0	1,255,250.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,149,877.25	53,539,480.94
120	Нийтлэг татварын бус орлого	79,149,877.25	53,539,480.94
120002	Хүүгийн орлого	0	1,467,247.97
120003	Торгуулийн орлого	0	1,476,512.97
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	78,835,377.25	50,477,720.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	78,835,377.25	50,477,720.00
120009	Бусад орлого	314,500.00	118,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	759,857,217.66	1,597,050,640.96
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,068,000.00	61,688,051.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,068,000.00	61,688,051.60
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	741,789,217.66	1,535,362,589.36
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	425,411,900.00	888,396,000.00
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	1,039,665.66	4,724,589.36
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	209,738,600.00	412,248,200.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	105,599,052.00	229,993,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	811,782,910.00	1,507,210,471.60
299990	Устгал	0	0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	811,782,910.00	1,507,210,471.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	379,827,834.34	879,907,641.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	259,989,462.36	409,597,759.72
210101	Үндсэн цалин	218,684,100.41	289,873,854.14
210102	Нэмэгдэл	41,305,361.95	117,816,818.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	0
210104	Урамшуулал	0	1,907,087.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,256,993.59	53,489,000.00
210201	Тэтгэврийн даатгал	20,442,571.29	36,372,500.00

210202	Тэтгэмжийн даатгал	1,948,752.46	4,279,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,593,904.43	3,423,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	381,977.70	855,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,889,787.71	8,558,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,734,400.39	28,234,330.92
210301	Гэрэл, цахилгаан	2,263,991.79	2,761,394.92
210302	Түлш, халаалт	26,470,408.60	25,472,936.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,276,960.00	22,410,780.00
210401	Бичиг хэрэг	2,340,760.00	3,142,500.00
210402	Тээвэр, шатахуун	12,613,200.00	16,624,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,323,000.00	2,644,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,763,000.00	2,024,900.00
210604	Урсгал засвар	1,763,000.00	2,024,900.00
2107	Томилолт, зочны зардал	1,938,000.00	5,008,000.00
210702	Дотоод албан томилолт	1,938,000.00	5,008,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,185,218.00	570,474.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	653,800.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	234,450.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,148.00	48,474.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	0
210807	Газрын төлбөр	23,820.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,683,800.00	358,572,397.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,173,300.00	357,922,397.11
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	510,500.00	650,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	431,955,075.66	627,302,829.85
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	431,952,067.66	627,302,829.85
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	425,411,900.00	591,337,300.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,039,665.66	15,638,090.25
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,500,502.00	20,327,439.60
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,008.00	0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,008.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	184,386,290.95	355,450,018.25
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	128,172,700.00	174,864,706.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	128,172,700.00	174,864,706.00
2200	Дотоод эх үүсвэрээр	128,172,700.00	174,864,706.00
223001	Бусад хөрөнгө	128,172,700.00	159,496,726.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	15,367,980.00

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-128,172,700.00	-174,864,706.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-146,100,000.00	-100,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	146,100,000.00	100,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	146,100,000.00	100,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-89,886,409.05	180,485,312.25
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	203,717,486.04	113,831,076.99
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	113,831,076.99	294,316,389.24

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,347,615,300.00	1,013,511,735.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	903,578,000.00	853,915,009.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	903,578,000.00	853,915,009.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	429,300,100.00	409,597,759.72
210101	Үндсэн цалин	302,668,900.00	289,873,854.14
210102	Нэмэгдэл	122,529,100.00	117,816,818.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	0
210104	Урамшуулал	4,102,100.00	1,907,087.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,662,500.00	53,489,000.00
210201	Тэтгэврийн даатгал	36,490,500.00	36,372,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,293,000.00	4,279,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,434,400.00	3,423,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	858,600.00	855,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,586,000.00	8,558,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	318,587,400.00	305,475,830.03
210301	Гэрэл, цахилгаан	29,652,700.00	20,339,601.86
210302	Түлш, халаалт	285,559,200.00	283,353,399.00
210303	Цэвэр, бохир ус	3,375,500.00	1,782,829.17
2104	Хангамж, бараа материалын зардал	23,091,600.00	22,050,780.00
210401	Бичиг хэрэг	3,142,900.00	3,142,500.00
210402	Тээвэр, шатахуун	16,348,400.00	16,264,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,600,300.00	2,644,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,117,000.00	26,296,580.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,092,100.00	15,367,980.00
210604	Урсгал засвар	11,024,900.00	10,928,600.00

2107	Томилолт, зочны зардал	5,111,100.00	5,008,000.00
210702	Дотоод албан томилолт	5,111,100.00	5,008,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,339,700.00	570,474.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	710,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	48,474.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,800.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	0
210807	Газрын төлбөр	138,300.00	0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	17,400.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,368,600.00	31,426,586.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,565,200.00	30,776,586.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	803,400.00	650,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	354,515,600.00	159,496,726.00
223001	Бусад хөрөнгө	354,515,600.00	159,496,726.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	89,521,700.00	100,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	89,521,700.00	100,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,347,615,300.00	1,153,347,429.75
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,113,479,700.00	1,102,869,709.75
320001	Орон нутгийн төсвөөс	883,485,900.00	872,875,909.75
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	229,993,800.00	229,993,800.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	234,135,600.00	50,477,720.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	50,477,720.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	234,135,600.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	82,801,981.38
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	222,637,675.38
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	48	48
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	Төсвийн байгууллага	2	2
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	23	23
620001	Удирдах ажилтан	10	10
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10
620003	Үйлчлэх ажилтан	3	3
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23	23
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	4
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,688,051.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	61,688,051.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,360,612.00
2104	Хангамж, бараа материалын зардал	360,000.00
210402	Тээвэр, шатахуун	360,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,000,612.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,000,612.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,327,439.60
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,327,439.60
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	20,327,439.60
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	61,688,051.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	61,688,051.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	61,688,051.60

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цэцэн-Уул сумын Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Сумын хөгжлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 61 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлт 91.4 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэн-Уул сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжтой холбоотой Төрийн хэмнэлтийн тухай хуулийг шинээр батлан мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод хяналтыг хэрэгжүүлэх нэгж байгуулаагүй, засаг дарга төсөв зарцуулалтад тавих хяналтаа хангалттай хэрэгжүүлээгүй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэн-Уул сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нутгийн захиргааны байгууллагууд нь нийтлэг НББ-ын бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэцэн-Уул сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 148,434.4 мянган төгрөгөөр буюу 12.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	113,831.1	294,316.4	180,485.3
Авлага	227,355.4	193,233.8	(34,121.6)
Бараа материал	36,349.6	37,453.0	1,103.4
Үндсэн хөрөнгө	621,750.3	622,717.6	967.3
Нийт хөрөнгө	999,286.4	1,147,720.8	148,434.4
Өр төлбөр	25.1	-	(25.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	999,261.3	1,147,720.8	148,459.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	999,286.4	1,147,720.8	148,434.4

Эх сурвалж: Цэцэн-Уул сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 294,316.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 180,485.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	113,831.10	294,316.40	180,485.30
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-	-
Дүн	113,831.10	294,316.40	180,485.30

Эх сурвалж: Цэцэн-Уул сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Мөнгөн хөрөнгө өмнөх оны үлдэгдлээс 180,485.3 мянган төгрөгөөр өссөн нь 2022 оны татварын давсан орлогоос сумын ОНХС, ЗДТГ-ын үйл ажиллагаанд төсөв баталж зарцуулсан, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх зарим ажил хийгдээгүй үлдэгдлээр үлдсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Мөнгөн хөрөнгөтэй холбоотой зөрчил илрээгүй.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 193,233.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 34,121.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	-	482.10	482.10
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага	29.50	-	(29.50)
Хувь хүмүүсээс авах авлага	227,325.80	192,751.60	(34,574.20)
Дүн	227,355.30	193,233.70	(34,121.60)

Эх сурвалж: Цэцэн-Уул сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Авлага данс өмнөх оны үлдэгдлээс 34,121.6 мянган төгрөгөөр буурсан нь урд онуудын хоршоог хөгжүүлэх сангийн авлага барагдсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Сумын Хоршоог хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй оршин суугаа хаяг нь тодорхойгүй зээлдэгч нарын 31,882.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулахаар, эрэн сурвалжлуулахаар шүүхэд хандаагүй зөрчилд албан шаардлага өгсөн байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данстай холбоотой үлдэгдэл тайланд тусгагдаагүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 37,453.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,103.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал	33,149.60	34,253.00	1,103.40
Бичиг хэргийн материал	2,848.70	2,790.00	(58.70)
Аж ахуйн материал	25,211.10	26,546.60	1,335.50
Сэлбэг хэрэгсэл	3,779.50	3,779.40	(0.10)
Түлш, шатах тослох материал	202.30	-	(202.30)
Барилгын засварын материал	598.00	627.00	29.00
Бусад хангамжийн материал	510.00	510.00	-
Мал амьтад	3,200.00	3,200.00	-
Дүн	36,349.60	37,453.00	1,103.40

Эх сурвалж: Цэцэн-Уул сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 1,103.4 мянган төгрөгөөр өссөн нь Хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй ирсэн 776.5 мянган төгрөгийн аж ахуйн материалыг данс бүртгэлд тусгасан, тайлант онд 25,724.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 25,397.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Бараа материалтай холбоотой зөрчил илрээгүй.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой бүртгэл байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 622,717.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 967.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	619,291.9	620,911.7	1,619.8
Барилга, байгууламж, орон сууц	467,791.5	442,555.8	(25,235.7)
Авто-тээврийн хэрэгсэл	41,221.9	35,552.8	(5,669.1)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	20,267.0	62,184.6	41,917.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	5,732.5	3,125.9	(2,606.6)
Бусад үндсэн хөрөнгө	81,535.0	74,748.6	(6,786.4)
Ном	2,744.0	2,744.0	-
Биет бус хөрөнгө	2,458.4	1,805.9	(652.5)
Программ хангамж	1,164.4	511.9	(652.5)
Бусад биет бус хөрөнгө	1,294.0	1,294.0	-
Дүн	621,750.3	622,717.6	967.3

Эх сурвалж: Цэцэн-Уул сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 967.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 15,367.9 мянган төгрөгөөр хөрөнгө худалдаж авч, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 64,792.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант оны элэгдлийн зардалд 57,443.2 мянган төгрөгийг тооцож, бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: ЗДТГ нь хандиваар ирсэн үндсэн хөрөнгийг 9,951.0 мянган төгрөгийн илүү тусгасан алдаа илэрсэнд залруулга хийсэн байна. Мөн эрх бүхий байгууллагын шийдвэргүй 15,367.9 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 0.00 мянган төгрөг болж, өмнөх оноос 25.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	25.10	-	(25.10)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-	-
Хувь хүмүүст төлөх өглөг	-	-	-
Байгууллагад төлөх өглөг	-	-	-
Дүн	25.10	-	(25.10)

Эх сурвалж: Цэцэн-Уул сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Өглөг дансны эцсийн үлдэгдэл 25.1 мянган төгрөг болж буурсан нь өмнөх оны ажиллагсадтай холбоотой өглөгийг барагдуулсан байна.

Аудитын илрүүлэлт: Өр төлбөртэй холбоотой зөрчил илрээгүй.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,147,720.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 148,459.5 төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	334,974.3	334,974.3	-
Хуримтлагдсан үр дүн	444,354.2	592,813.7	148,459.5
Өмнөх үеийн үр дүн	3,886,603.8	444,354.2	(3,442,249.6)
Тайлант үеийн үр дүн	(3,442,249.6)	148,459.5	3,590,709.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	219,932.7	219,932.7	(0.0)
Дүн	999,261.3	1,147,720.8	148,459.5

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Цэцэн-Уул сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан.

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

ТТЗ нь шууд захирагчдын төсвийн төслийг нэгтгэдэггүй байна. Шууд захирагч нар тус тусдаа төсвийн төслийг боловсруулан ТЕЗ-ийн холбогдох хэлтэст нэгтгүүлж байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 8 дугаар тогтоолоор ТТЗ-ийн 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагыг 1,635,493.7 мянган төгрөгөөр баталжээ. Үүнээс орон нутгийн байгууллагын 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээ 883,624.4 мянган төгрөг байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 317,038.6 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 183,878.2 мянган төгрөгийг аймгийн ОНХС-аас сумд олгох орлогын шилжүүлгээс, 25,241.6 мянган төгрөгийг ОНХС-д малын тоо толгойн албан татварын 2022 оны үлдэгдлээс, 73,280.2 мянган төгрөгийг ОНХС-ын 2022 оны үлдэгдлээс, 297,258.7 мянган төгрөгийн Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардалд орон нутгийн төсвөөс, 163,572.0 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоос, 80,000.0 мянган төгрөгийг Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс, 9,521.7 мянган төгрөгийг ХХСангийн эх үүсвэр 2022 оны үлдэгдлээс, 31,092.1 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, ЗДТГ-ын 372,940.1 мянган төгрөгийн төсөв, ИТХ-ын 81,670.5 мянган төгрөгийг төсвөөс тус тус бүрдүүлэхээр сумын ИТХ-аар анх баталжээ.

Аймгийн 2023 оны төсвийн тодотголоор татварын болон татварын бус орлогыг 9,407.0 мянган төгрөгөөр, сумд олгох санхүүгийн дэмжлэгийг 96,209.6 мянган төгрөгөөр, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 46,115.6 мянган төгрөгөөр, ОНХСанд малын тоо толгойн албан татварыг 758.4 мянган төгрөгөөр, ЗДТГ-ын төсвийг 83,610.4 мянган төгрөг, ИТХ-ын төсвийг 22,006.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Аймгийн төсвийн тодотголд үндэслэн тус сумын 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг тооцоолоход 1,918,847.0 мянган төгрөг байна.

Гүйцэтгэлээр санхүүгийн дэмжлэгээс 412,248.2 мянган төгрөгийн, аймгийн ОНХС-с сумдад олгох шилжүүлгээс 229,993.8 мянган төгрөгийн, Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардалд орон нутгийн төсвөөс 297,258.7 мянган төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 80,000.0 мянган төгрөгийн, татварын болон татварын бус орлогоос 172,979.0 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 572,376.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь батлагдсан төсвөөс 218,087.4 мянган төгрөгөөр дутуу байна. Энэ нь аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 1,000.0 мянган төгрөгөөр дутуу олгогдсон, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг төлөвлөдөггүй, урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тооцсон зэрэг нөлөөлж байна.

/мянган төгрөгөөр/

Д/д	Санхүүгийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Санхүүгийн дэмжлэг	413,248.20	412,248.20	(1,000.00)
2	Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг	255,993.80	229,993.80	(26,000.00)
3	Татварын болон татварын бус орлого	172,979.00	163,369.00	(9,610.00)
4	Урьд оны үлдэгдэл	779,367.30	-	(779,367.30)
5	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	50,477.70	50,477.70
6	Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардал	297,258.70	297,258.70	-
ДҮН		1,918,847.00	1,153,347.40	(765,499.60)

Татварын болон татварын бус орлогоор 215,014.1 мянган төгрөгийг бүрдүүлж татварын буцаан олголтод 17,311.0 мянган төгрөгийг, санхүүжилтэд 163,369.0 мянган төгрөгийг олгож давж биелсэн 34,334.1 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд байршуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,013,511.7 мянган төгрөг буюу 75.2 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг хэмнэсэн, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан зарим ажил хийгдээгүй, Хоршоо хөгжүүлэх сангаас төлөвлөсөн хэмжээнд зээл олгоогүй, ИТХ, ЗДТГ-т санхүүжилт дутуу олгосон зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	103,676.70	98,309.70	5,367.00	94.82
2	Засаг даргын Тамгын газар	502,642.60	469,460.10	33,182.50	93.40
3	Орон нутгийн хөгжлийн сан	354,515.60	159,496.70	195,018.90	44.99
4	Хоршоог хөгжүүлэх сан	89,521.70	100.00	89,421.70	0.11
5	Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардал	297,058.70	286,145.20	10,913.50	96.33
ДҮН		1,347,415.30	1,013,511.70	333,903.60	75.22

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2023 онд нэмэлт санхүүжилтээр 61,688.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 41,360.6 мянган төгрөгийг цалин, тээвэр шатахуун, дотоод албан томилолт, бараа

үйлчилгээний бусад зардалд зарцуулж, 20,327.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Сумын хэмжээнд тусгайлан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр байхгүй бөгөөд сумын хөгжлийн төлөвлөгөөнд улс, аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй "Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр-III", "Чадварлаг багш" дэд хөтөлбөр, "Чадварлаг эмч" дэд хөтөлбөр зэрэг арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийг тусгасан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Цэцэн-Уул сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баасанжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэцэн-Уул сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 1/40 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1,871,787.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 28,076.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 21,057.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, аудитыг гүйцэтгэх шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төлөвлөгөө гаргаагүй, батлагдсан төсвийн хүрээнд зардал гарган ажилласан байна. Төсөвт бодит хэмнэлт үүсэн зардал байхгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгаагдагч байгууллагатай хамааралтай 18 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын илрүүлэлт: Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил илрээгүй байна.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Цэцэн-Уул сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төсөв захирагчдын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг барагдуулахаар шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад албан хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх зөвлөмж хүргүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	63,246.6	1	63,246.6	100
Нийт дүн	1	63,246.6	1	63,246.6	100

Зөвлөмжийн биелэлтийн талаар Fas системд мэдээлсэн байна.

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчилд зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн зөрчил нь шинж чанарын хувьд материаллаг тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: ТШЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжсан Галуутайн голын гүүрний далан засах ажилд шууд гэрээ байгуулан гэрээлэгчийн хувийн дансанд 14,000.0 мянган төгрөг шилжүүлсэн ч тухайн ажил тайлант онд огт хийгдээгүй, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас эрх шилжиж ирсэн сумын төвийн гэрэлтүүлгийн ажлын гэрээ хугацаандаа хийгдээгүй, тайлант онд 20,000.0 мянган төгрөгийн ажил хийгдсэн ч үр дүнгүй байна.
- Засаг даргын нөөц хөрөнгөөс нутгийн зөвлөлийн уулзалт золгуут хийх хүнсний материал худалдан авсан, аймгийн 100 жилийн ойд хандив өгсөн хүмүүст гарын бэлэг, дурсгалын зүйл худалдан авч 6,899.0 мянган төгрөгийн зориулалт бус зардал гаргасан байна.
- Хоршоог хөгжүүлэх сангаас санхүүгийн дэмжлэг авч гэрээт хугацаандаа төлөөгүй иргэдийг шүүхэд шилжүүлээгүй, шүүхээс гарсан шийдвэрийг хэрэгжүүлээгүй иргэдийн зээлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлэн шийдвэрлүүлээгүй 16 иргэний 31,882.4 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэл зэрэгт хяналт тавьж, төсвийг зохистой удирдаагүй зөрчил илэрсэн байна.

Энэ нь УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 1.4.2, 3.4, 3.6", Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.13.7, 8.4 дэх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг үр ашигтай удирдаж, гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 30-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Тоо	Дүн	
ТШЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй	1	0					1	0					
Дүн	1	0					1	0					

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Г.БААСАНЖАРГАЛ



Огноо: 2024-03-18